



# СОЁМБОМ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

# МЭДЭЭ

188 /188/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.11.25

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

## 2021 ОНЫ ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ШИЛДЭГ БҮТЭЭЛҮҮД ТОДОРЛОО



шалгарлаа. "Шинэ бүтээл, оновчтой санал" номинацын тэргүүн байрт ҮБХИС-ийн ЦНДС-ийн багш, дэд хурандаа З.Нарангэрэлийн зохиосон "Сургалтын үйл ажиллагаанд ашиглах программ хангамжийн хөгжүүлэлт /програм", тусгай байрт Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн захирагчийн орлогч, ахлах инженер, ахмад П.Ганхуягийн зохион бүтээсэн "Хуягт танкны техникийн олон үйлдэлт засвар үйлчилгээний хөдөлгөөнт байр" бүтээлүүд шалгарсан юм.

Шалгарсан бүтээлүүдийн эздэд шагнал гардуулсны дараа Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр баяр хүргэж хэлсэн үгэндээ "Салбарын эрдэмтэн, судлаачид, Зэвсэгт хүчний залуу инженерүүд, офицерууд маань инновацыг хөгжүүлэх чиглэлээр тодорхой санал, санаачлагуудыг гаргаж, батлан хамгаалах эрх ашигт нийцсэн цэргийн зориулалттай зарим төрлийн бүтээгдэхүүнийг өөрсдийн хүчээр үйлдвэрлэх ажлыг амжилттай эхлүүлж, тусгай зориулалтын цэргийн техник, орон зайн тандалт, агаарын тагнуулын зориулалт бүхий нисгэгчгүй нисэх төхөөрөмжүүд, богино долгионы дунд чадлын радиостанцын загваруудыг гарган, дотооддоо үйлдвэрлэх, турших ажлыг амжилттай эхлүүлсэн нь шинжлэх ухаан, технологийн хөгжилд ахиц гарсан, цаашид илүү эрч хүчтэй бүтээж туурвих урам зоригийг сэргээсэн онцгой үйл явдал болсон.

Цаашид Бид "Шинжлэх ухаан, технологи, инновацыг 2021-2030 онд хөгжүүлэх бодлого"-оо тодорхойлж, улс орныг батлан хамгаалах үйл ажиллагаанд шинжлэх ухаан, технологи, инновацын үр дүнг нэвтрүүлэх, түүний хөгжлийг дэмжих, эрдэм шинжилгээний ажилтнуудын идэвх, санаачилгыг өрнүүлэх, оюуны чадавх, мэдлэгийг арвижуулах, батлан хамгаалахын аж үйлдвэрлэлийн суурийг улам бэхжүүлэх, Зэвсэгт хүчний туршилт-үйлдвэрлэлийн төвүүдийн үйл ажиллагааг жигдрүүлэх, бүтээсэн бүтээл, зэвсэглэл, цэргийн техник, тоног төхөөрөмжөө Зэвсэгт хүчиндээ нэвтрүүлэх нь бидний ойрын ирээдүйн зорилт болж байгааг онцлон тэмдэглэж байна" гэлээ.

Монгол Улсад орчин цагийн шинжлэх ухааны байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ой, "Шинжлэх ухааны ажилтны өдөр"-ийг тохиолдуулан Батлан хамгаалахын сайдын нэрэмжит 2021 оны шинжлэх ухаан, технологийн шилдэг бүтээл шалгаруулах уралдаанд амжилттай оролцсон бүтээлийг шалгаруулах арга хэмжээ боллоо.

Тус арга хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Батлан хамгаалахын дэд сайд, Шинжлэх ухаан, технологийн зөвлөлийн дарга Б.Баярмагнай, Сайдын зөвлөх Ц.Дашзэвэг, яамны СБТГ-ын дарга, хурандаа Ч.Гандирваа, ТЗУГ-ын дарга, хурандаа С.Ванчинхүү нар оролцлоо.

Энэ жилийн хувьд "Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал" чиглэлээр тэргүүн байрт ҮБХИС-ийн зөвлөх профессор, БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний гэрээт ажилтан, доктор А.Хүү-Ухнаагийн туурвисан "Пиротехник судлал" 3 боть бүтээл, дэд байрт ҮБХИС-ийн профессор, БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Ц.Дашзэвэгийн туурвисан "Цэрэг дайчдынхаа төлөө нэгэн зууны сэтгэл, зүтгэл" ном, тусгай байрт БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, профессор П.Цэдэвийн туурвисан "Цэргийн харилцан ажиллагааны онол, арга зүйн үндэс" ном тус тус шалгарав.

"Зэвсэглэл, техник технологи" төрөлд тэргүүн байрт Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн захирагч, хурандаа М.Батдоржийн удирдаж зохион бүтээсэн "Хөнгөн хуягласан байлдааны машин-Мазаалай", дэд байрт ҮБХИС-ийн багш, ахмад С.Наранхүүгийн зохион бүтээсэн "Камикадзе нисгэгчгүй нисэх аппарат", БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Хуралбаатарын зохион бүтээсэн "Нисгэгчгүй нисэх аппаратын катапулт" бүтээлүүд шалгарсан юм. Түүнчлэн "35 хүртэлх насны залуу судлаачийн бүтээл"-д тэргүүн байрт Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн харьяа "Нисгэгчгүй нисэх системийн судалгаа, туршилтын төв"-ийн дарга, ахмад И.Зоригийн зохион бүтээсэн "Орон зайн тандалт судалгаа, тагнуулын зориулалт бүхий нисгэгчгүй нисэх төхөөрөмж", тусгай байрт Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн Автотехникийн агрегат засварын хэсгийн дарга-ашиглалтын инженер, дэслэгч М.Шийрэвноровын зохиосон тагнуул, давшилтын "Хилэнцэт" бүтээл, "Шилдэг инновацын бүтээл"-ийн тэргүүн байрт Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн харьяа "Радиоэлектроникийн туршилт, судалгааны төв"-ийн дарга, хурандаа Р.Энхнасангийн удирдаж зохион бүтээсэн "Монрадио-1000", тусгай байрт ҮБХИС-ийн багш, ахмад С.Наранхүүгийн зохион бүтээсэн "Вертикаль хөөрөлт, буулттай нисгэгчгүй нисэх аппарат" тус тус

## ШАГНАЛЫН ХҮР БУУЛАА



Хөвсгөл нуурын эко системийг хамгаалах, нуурын ёроолын аюултай хог хаягдлыг цэвэрлэх, бохирдлыг бууруулах зорилгоор тус нуурт 1985 онд живсэн "Сүхбаатар" хөлөг онгоцыг амжилттай татан гаргасан билээ. Тэгвэл хөлөг онгоцыг татан гаргах ажиллагааг амжилттай зохион байгуулж, байгаль цаг уурын хүнд нөхцөлд мэргэжлийн ур чадвар гарган ажилласан ЗХЖШ, ОБЕГ-ын харьяа анги, байгууллагын зарим офицер, ахлагч, ажилтан албан хаагчдыг Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд одон медаль, салбарын шагналаар шагнасныг Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр өнөөдөр гардуулан өглөө.

Тухайлбал, Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн захирагч, хурандаа Г.Эрдэнэбаяр, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн жолооч Д.Батдорж, Цэргийн гавьяаны одонгоор Зэвсэгт хүчний 7780 дугаар ангийн жолооч, сургагч ахлагч Б.Мөнхтөр, Цэргийн хүндэт медалиар Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн салааны ахлагч, ахлах ахлагч Г.Батбаатар зэрэг алба хаагчдыг шагнасан юм.

Мөн Батлан хамгаалах яамны "Хүндэт тэмдэг"-ээр ЗХЖШ-ын Барилга-инженерийн цэргийн удирдах газрын орлогч, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, хурандаа Ц.Ганхөлөг, ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлагын газрын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Б.Ганболд, "Батлан хамгаалахын тэргүүний ажилтан" цол тэмдгээр ОБЕГ-ын Уул уурхайн аврах 09 дүгээр ангийн захирагчийн орлогч, штабын дарга, хошууч Б.Алтан-Очир, "Дайчин алдар II" медалиар Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн

танкны ротын салааны ахлагч, ахлах ахлагч Г.Батбаатар, "Дайчин алдар III" медалиар ОБЕГ-ын Үндэсний аврах бригадын техник тоног төхөөрөмж хариуцсан ахлах мэргэжилтэн, ахлах дэслэгч Д.Батчулуун, "Эх орны төлөө II хүндэт тэмдэг"-ээр Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийн ахлах гүүр тавигч-жолооч, ахлагч Ц.Бат-Ирээдүй, "Эх орны төлөө III хүндэт тэмдэг"-ээр ОБЕГ-ын Үндэсний аврах бригадын гал унтраах автомашины жолооч, ахлах ахлагч Х.Цэрэнтогтох, Нийслэлийн онцгой байдлын газрын гал түймэр унтраах, аврах 26 дугаар ангийн гал унтраах автомашины жолооч, ахлах ахлагч Б.Батбаатар нарын алба хаагчид шагнагдаа.

Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр шагнагдсан бүрэлдэхүүнд хандан "Томилогдсон ажлын хэсэг эх дэлхийгээр авран хамгаалах, байгаль эколого цэвэрлэх маш том зорилгыг амжилттай эхлүүлсэн. Монгол улсад үйл төрлийн, далайн гүнээс татан гаргалт хийсэн туршлага өмнө нь байгаагүй. Манай Зэвсэгт хүчин, Онцгой байдлын алба, ШУТИС зэрэг олон байгууллагын хамтарсан ажлын хэсэг шинжлэх ухаан, техник технологийн үндэслэлийг нь гаргахаас эхлээд татан гаргалтыг амжилттай хийсэн. Ерөнхийлөгч үүнийг бэлгэцээлтэй үйл явдал болсон хэмээн онцлон тэмдэглэсэн. Дэлхийн болон Ази тивийн цэвэр усны эх ундарга болсон Хөвсгөл далайг цэвэрлэх ажил 2024 он хүртэл үргэлжилнэ. Далайн усанд байгаа бусад техникүүдийг татан гаргах ажиллагааг үргэлжлүүлэн зохион байгуулах болно. Ингээд өөрсдийн хичээл зүтгэл, ажлын үр дүнгээ үнэлүүлж, Улс тунхаглсны баярын ойн босгонд шагнал хүртсэн та бүхэнд баяр хүргэж, ажлын өндөр амжилт хүсье" гэв.

## ШИНЭ ДАЙЧИД ЭНЭ ӨДӨР ТАНГАРАА ӨРГӨЖ БАЙНА



Энэ өдөр Монгол Улсын Зэвсэгт хүчинд 2021 оны хоёрдугаар ээлжээр хугацаат цэргийн албанд

татагдан ирсэн дайчдын Цэргийн тангараг өргөх ёслол хүндэтгэлийн арга хэмжээ боллоо. БХЯ, ЗХЖШ,

төрлийн цэргийн командлалын удирдах бүрэлдэхүүн Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад очиж

тангаргийн баярт оролцдог уламжлалтай бөгөөд энэ удаад Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, БХЯ-ны ГХАГ-ын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ, ЗХЖШ-ын МТГ-ын штабын дарга, хурандаа З.Баянмөнх, БЗД-ийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд хурандаа О.Энх-Амар нар Зэвсэгт хүчний 015 дугаар ангид, Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар, Зэвсэгт хүчний ХЗЦ-ийн командлагч, хошууч генерал Б.Амгаланбаатар, Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа Г.Ялалт нар Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн тангаргийн баяруудад тус тус оролцлоо.

Сар гаруйн өмнө эх орныхоо өнцөг булан бүрээс цэргийн албанд мордсон эдгээр дайчид өнгөрсөн хугацаанд цэргийн албанд дасах, анхан шатны бэлтгэл сургалтдаа бүрэн хамрагдаад ийнхүү эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ үнэнчээр биелүүлэхээ батлан тангараглаж байгаа билээ.

Цэргийн тангараг өргөөд сэтгэл догдлон, бахдал дүүрэн зогсож буй Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн шинэхэн байлдагч нарт хандан Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар "Ард түмэндээ инженер сапёрын хороо хэмээн

алдаршсан Зэвсэгт хүчний 014 дүгээр ангид цэргийн жинхэнэ алба хаахаар ирсэн эр цэргүүд та бүхэн Монгол Улс анхдугаар Үндсэн хуулиа баталж Бүгд найрамдах улс тунхагласны 97 жилийн баярын өдрийг тохиолдуулан цэргийн тангараг өргөлөө. Та бүгд үндсэн хуулиар хүлээсэн журамт үүргээ ийнхүү биелүүлснээр ээж аавын хүүгээс эх орны эр цэрэг болж байна. Та бүхний алба хааж буй анги 80 жилийн баялаг түүхтэй, Зэвсэгт хүчний ууган ангиудын нэг юм. Тиймээс та бүхэн ангийнхаа баатарлаг түүх, удирдлага, хамт олноос ихийг сурахын зэрэгцээ цэргийн эрдэмд шамдан суралцаж, сурлага хөдөлмөрөөрөө манлайлагч байгаарай. Өргөсөн тангарагтаа үнэнч, эх орныхоо бүтээн байгуулалтад хувь нэмрээ оруулсан үлгэр жишээ залуус байна гэдэгт итгэл төгс байна. Та бүгдийн цаашдын ажил амьдралд амжилт хүсье" гэв.

Энэ жилийн цэргийн тангаргийн ёслолын ажиллагаа "COVID-19" цар тахлын улмаас цахим хэлбэрээр зохион байгуулагдаж байгаа тул цэргийн алба хаагчид, тэдний ар гэрийн төлөөллийг Google meet, Messenger, Zoom апплекэйшн зэргийг ашиглахаас гадна газар дээрээс нь live хийж шууд дамжуулан цахимаар уулзуулах ажлыг амжилттай зохион байгуулаа.

ҮЙЛ ЯВДАЛ

## БНПУ-ЫН СЕЙМИЙН ДЭД МАРШАЛЫГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



Монгол Улсын ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг өчигдөр Бүгд Найрамдах Польш Улсын Сеймийн дэд маршал эрхэмсэг хатагтай Маллосата Говеска тэргүүтэй төлөөлөгчдийг хүлээн авч уулзав.

Монгол Улс, Бүгд Найрамдах Польш Улсын дипломат харилцаа 1950 оноос эхлэлтэй бөгөөд хоёр улсын найрсаг харилцаа нь олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдал, түүний дотор батлан хамгаалах салбарын гадаад хамтын ажиллагааг

хөгжүүлж, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, энх тайван, тогтвортой байдлыг сахин хамгаалах үндсэн зарчимд тулгуурлан хөгжиж байна.

Энэхүү уулзалтаар талууд хоёр улс дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ой өнгөрсөн онд тохиосон боловч цар тахлын улмаас хойшлогдсон арга хэмжээг нөхөж зохион байгуулахаар төлөвлөх, мөн Элчин сайдын яамыг дахин ажиллуулах болсонд талархал илэрхийлэхийн ялдамд хоёр орны батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжийн талаар харилцан санал солилцлоо.

Хошууч Б.СЕРГЕЙ

## 30 ЖИЛИЙН ОЙН БАЯРЫН ХУРАЛ, БАРИМТАТ КИНОНЫ НЭЭЛТИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Батлан хамгаалахын сайдын 1991 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн тушаалаар хөгжмийн бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, мэргэжлийн ур чадварыг нь өндөр түвшинд байлгах зорилгоор цэргийн хөгжмийн зохион байгуулалт, байршил, орон тоонд өөрчлөлт оруулжээ. Энэ тушаалын дагуу Зэвсэгт хүчний доторх мэргэжлийн урлагийн байгууллагууд, нэгтгэл, ангиудын үлээвэр найрал хөгжимд ахлагчдыг сургаж бэлтгэх Цэргийн хөгжмийн байнгын курсыг тухайн үеийн ЦНДС-ийн үлээвэр найрал хөгжмийн

байр, танхим, хөгжмийн зэмсэг, материаллаг баазыг түшиглэн ЦНДС-ийн хөгжмийн албаны дэргэд байгуулсан нь өдгөө Цэргийн хөгжмийн коллеж нэртэйгээр 30 жилийн ойгоо угтаж байна. Энэ хүрээнд тус коллежийн хамт олон өчигдөр баярын хурлаа хийж, "Цэргийн хөгжмийн коллеж-30 жил" баримтат киноны нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Уг ёслолын үйл ажиллагаанд Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагч, хурандаа Ж.Болдбаатар, ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газрын дарга, бригадын

генерал С.Дашзэвэг, ҮБХИС-ийн захирал, бригадын генерал П.Жаргалан, ЗХЖШ-ын Цэргийн хөгжмийн алба, Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн дарга, хурандаа Ч.Гансүх нарын хүндэт зочид, төлөөлөгчид оролцож ойн баярын мэндчилгээг өргөн дэвшүүлж дурсгалын зүйлсийг гардуулсны сацуу зарим алба хаагчдад салбарын шагналыг гардууллаа.

Ташрамд дурдахад энэ сарын 27-ны өдөр тус коллежийн 30 жилийн ойд зориулсан хүндэтгэлийн тоглолт Соёлын төв өргөөнд зохион байгуулагдах юм.

## ХУРАНДАА ЦОЛ ОЛГОВ



Монгол Улс анхдугаар Үндсэн хуулиа баталж Бүгд найрамдах улс тунхагласны 97, Орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан эрхэлсэн албандаа үр бүтээлтэй ажиллаж байгаа алба хаагчдад ЗХЖШ-ын даргын тушаалаар албан тушаалын зэрэглэлийн хурандаа цол олголоо.

Тухайлбал, Цэргийн төв эмнэлгийн дарга-ерөнхий эмч, дэд хурандаа Б.Энх-Од, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, дэд

хурандаа Б.Энхболд, ОБЕГ-ын Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгааны хэлтсийн дарга, дэд хурандаа Д.Бат-Эрдэнэ, Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын дарга, гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч, дэд хурандаа Г.Галбадрах нарт хурандаа цол олгосон юм. ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг цол гардуулсныхаа дараа шинэхэн хурандаа нарт хандан "Зэвсэгт хүчний 100

жилийн түүхт ойн жил эрхэм хүндтэй цол хүртсэн та бүхэнд баяр хүргэе. Хурандаа хэмээх энэ эрхэм цолыг хүртэхэд таны албаны төлөөх хүчин чармайлт, хичээл зүтгэл, хамт олон, гэр бүлийн тань дэмжлэг их байгаа. Цол хүртэхээс илүү цолныхоо нэр хүндийг даана гэдэг хамгийн том шалгуур байдаг. Үүрэг хариуцлага, ачаа даах чадвараараа бусдадаа үлгэрлэж, харилцаа, хүндлэлээрээ хамт олондоо үнэлэгдэх учиртай юм шүү. Та бүхний цаашдын ажил, албанд өндөр амжилт хүсье" гэсэн юм.

## "ТҮҮХЭН ЗАМНАЛ ӨМНӨ БА ИРЭЭДҮЙ"



Цэргийн ар талын танхим байгуулагдсаны түүхт 40 жилийн ойн хүрээнд хийгдэж буй олон талт ажил, арга хэмжээнүүд эдгээр өдрүүдэд үргэлжилж байна. Тус ажлын нэг хэсэг болох "Түүхэн замнал өнөө ба ирээдүй" сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал өчигдөр "Тэмүүжин өрлөг" сургуулийн хурлын зааланд зохион байгуулагдаа. Тус хуралд ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ, нийгмийн түншлэл хариуцсан дэд захирал, хурандаа Б.Өлзийхуяг, Зэвсэгт

хүчний ХЦЗК-ын Материал, техникийн хангалтын хэлтсийн дарга, хурандаа Л.Бат-Эрдэнэ, ҮБХИС-ийн БХЭШХ-ийн Батлан хамгаалах дүн шинжилгээний төвийн дарга, хурандаа Л.Баатар, Цэргийн ар талын тэнхимийн дарга, хурандаа Х. Эрдэнэчимэг, АБДС-ийн ЭЗМТ-ийн профессор багш, доктор Д.Эрдэнэчимэг, ХСИС-ийн Хилийн албаны сургуулийн багш, хошууч Н.Лхагважав болон албаны бусад хүмүүс оролцлоо. Түүхт ойн хүрээнд зохион байгуулагдсан тус

эрдэм шинжилгээний бага хуралд "Цэргийн ар талын танхимын түүхэн замнал", "ҮБХИС-ийн цэргийн ар талын тэнхимийн хүний нөөц бэлтгэж буй тоглоцоо, цаашдын чиг хандлага", "Боловсролын шинэчлэл ба багшийн хөгжил", "Хуурай замын цэргийн материал техникийн хангалтын хувьсал, шинэчлэлт, тулгамдаж буй асуудал, "Материал техникийн хангалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага" зэрэг сэдвүүдээр бэлтгэгдсэн илтгэлүүдийг холбогдох албан тушаалтнууд хэлэлцүүлсэн юм.

## ЦАХИМ СУРГАЛТЫН ЖИШИГ ТАНХИМТАЙ БОЛЛОО



ҮБХИС-ийн болон Артиллерийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 100 жил, Зэвсгийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсний 30 жилийн ойн хүрээнд хурандаа Д.Сосорбурамын нэрэмжит "Буудлагын зэвсгийн цахим хичээлийн танхим"-ыг байгууллаа. Энэ нь өдгөө өргөн цар хүрээтэй яригдах болсон идэвхтэй сургалтын аргыг хэрэгжүүлэх сургалтын технологид нийцсэн шийдэл юм. Тус танхим хүний харах, сонсох, мэдрэх гэсэн гурван мэдрэхүүд тулгуурлан төхөөрөмжлөгдсөн ба суралцагчдын сурах идэвх, хүсэл сонирхлыг төрүүлж, сургалт явуулах

боломжтойгоороо шинэлэг юм. Мөн зэвсгийн өрөөтэй учир суралцагчид Зэвсэгт хүчний анги, салбарт зэвсгийн өрөөг хэрхэн төхөөрөмжилж болоход суралцаж байгаагаараа ач холбогдолтой. Түүнчлэн зэвсгийн өрөөнд тавигдах бүхий л шаардлагыг хангахын зэрэгцээ сүүлийн үеийн дэвшилтэд тоног төхөөрөмжийг ашигласан юм. Гучин жилийн хугацаанд төгссөн бүх төгсөгчдийн хандив, хичээл зүтгэлээр бий болсон тус танхимын хувьд дэлхийн нийтийг хамарсан цар тахлын үед багш нарт тавигдсан тусгай мэргэжлийн сургалтыг



цахимаар явуулах шаардлагыг хангасныг мэргэжлийн багш

нар нь онцолж төгсөгчдөдөө талархал илэрхийлэв.